



ЗАСГИЙН ГАЗРЫН БАЙРУУДЫН  
НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН  
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 12 сарын 28 өдөр

Дугаар А179

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Захирлын зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ-ын "Спорт заал, дугуй танхим, автографийг байгууллага, иргэдэд түрээслүүлж ашиглуулах журам"-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү журмыг батлагдсан өдрөөс дагаж мөрдөн, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, бүртгэлийн хэлтэс (Г.Долгорсүрэн), Захиргаа, хүний нөөцийн хэлтэс (Н.Оюунцэцэг)-т тус тус үүрэг болгосугай.
3. Тус тушаал батлагдсантай холбогдуулан Захирлын 2017 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 235 дугаар тушаал, 2020 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн спортын заалыг байгууллага, иргэдэд ашиглуулах журмыг тус тус хүчингүй болгосугай.

Спортын заалыг байгууллага, иргэдэд ашиглуулах журмыг тус тус хүчингүй болгосугай.

ЗАХИРАЛ



Ө.ЛУВСАНРЕНЧИН

Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газрын захирлын 2022 оны 11 дугаар сарын 28.-ны өдрийн 11:00 тоот тушаалын хавсралт

**ЗАСГИЙН ГАЗРЫН БАЙРУУДЫН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР  
ТӨААТУГ-ЫН СПОРТ ЗААЛ, ХУРЛЫН ТАНХИМ, АВТОГРАЖИЙГ  
БАЙГУУЛЛАГА ИРГЭДЭД ТҮРЭЭСЛҮҮЛЖ АШИГЛУУЛАХ ЖУРАМ**  
**NUG-J-018**

**1 дүгээр зүйл. Нийтлэг үндэслэл**

1.1. Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газрын (ЗГБНҮГ)-ын спорт заал, дугуй танхим, автогражийг байгууллага иргэдэд ашиглуулах түрээслүүлэхэд энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Спорт заал, дугуй танхим, авторажийг байгууллага, иргэдтэй байгуулсан хамтран ажиллах гэрээ болон захиалагч буюу үйлчлүүлэгчийн тавьсан хүсэлт, төлбөрийн баримтыг үндэслэн тус журамд тогтоосон үнэ тариф, гэрээний заалтыг мөрдлөг болгон түрээслүүлж, ашиглуулна.

**2 дугаар зүйл. Үйлчлэгч байгууллагын эрх үүрэг**

2.1. Захиалагч буюу үйлчлүүлэгчийг ирэхээс өмнө нэг цагийн өмнө үйлчлүүлэгч байгууллагын зүгээс заал, танхимиын цэвэрлэгээ үйлчилгээг бэлэн болгож, халаалт дулаан, бусад хэрэгслэлийн бэлэн байдлыг хангасан байна.

2.2. Заал, танхим, гражийг зөвхөн зориулалтын дагуу ашиглаж, түрээслэнэ.

2.3. Захиалагч буюу үйлчлүүлэгч заал, танхим, граж ашиглахаар бичгээр хүсэлтээ өгсөн бол хүлээн авснаас хойш гурван хоногт багтаан хариу өгнө.

2.4. Цаг үеийн шаардлагаар болон хамтран ажилладаг байгууллагаас яаралтай арга хэмжээ зохион байгуулах үед өмнө төлөвлөсөн заал, танхим, граж ашиглуулах ажиллагааг цуцлах, хойшлуулах зэрэг зохион байгуулалтыг хийж болно.

2.5. Заалт, танхим, гражийг заагдсан цагийн хуваариас хоцорч түрээслэх, ашиглах тохиолдолд хоцорсон хугацааг нөхөж тооцохгүй.

2.6. Гэрээт газрын цаг дээр хамааралгүй үйлчлүүлэгч заал, танхим, гражийг ашиглэх эрхгүй.

**3 дугаар зүйл. Үйлчлүүлэгч байгууллагын эрх үүрэг**

3.1. Заал, танхим, гражийг ашиглахдаа хөдөлмөрийн аюулгүй байдлын журмыг мөрдөж, зөв боловсон, ариун цэврийн шаардлагыг сахин ашиглана.

3.2. Ашиглалтын явцад цахилгаан, сантехникийн болон бусад тоног төхөөрөмжид ослын шинж тэмдэг илэрвэл үйлчлүүлэгч байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.

3.3. Заал, танхим, гражийг түрээслэж, ашигласны дараа үйлчлэгч байгууллагын хариуцсан албан хаагчид нь хүлээлгэн өгнө.

3.4. Заал, танхим, гражид утаат тамхи, согтууруулах ундаа, тэсэрч дэлбэрэх бодис зэрэг төрийн тусгaa хамгаалалттай газарт хориглогдсон эд зүйлс авч орох, байрлуулахыг хориглоно.

3.5. Заалны тоглолтын талбай дээр зориулалтын хувцас хэрэгслэлтэй үйлчлүүлэгч гарахыг хориглоно.

3.6. Автографжаар үйлчлүүлэгч нь автомашины түлхүүрээ жижүүрт хүлээлгэн өгөх бөгөөд машин хааж тавих тохиолдолд утасны дугаар болон түлхүүрээ заавал үлдээнэ.

#### **4 дүгээр зүйл. Төлбөр, тооцоо хийх**

4.1. Заал, танхим, гражийн түрээс ашиглалтын төлбөрийг үйлчлүүлэгч байгууллагын санхүүгийн баримтыг үндэслэн бэлэн болон бэлэн бусаар хийнэ.

4.2. Түрээслэжт буюу байгууллага, иргэн захиалганд заасан хугацаанаас илүү ашигласан тохиолдолд төлбөрийг нэмж, нөхөж төлнө.

4.3. Спорт заалны нэг цагийн төлбөр 44,000; дугуй танхимын нэг цагийн төлбөр 66,000 төгрөг; автографжийн төлбөр зуны улиралд (5 дугаар сарын 01-ны өдрөөс 9 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл)-д өдрөөр 3850 төгрөг, хоногоор 5500 төгрөг, өвлийн улиралд (10 дугаар сарын 01-ны өдрөөс 4 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл) өдрөөр 5000 төгрөг, хоногоор 11000 төгрөг байна. Үүнд нэмэгдсэн өртгийн албан татварын зардал багтсан болно.

#### **5 дугаар зүйл. Хариуцага**

5.1. Энэхүү журмыг зөрчсөн үйлчлүүлэгчийн гэрээг цуцлах, хохирлыг нөхөн төлүүлэх болон албан хаагчид Хөдөлмөрийн тухай хууль болон Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газрын хөдөлмөрийн Дотоод журамд заасан хариуцлага хүлээлгэнэ.